

## ОРХОНЫ ХӨНДИЙГӨӨС ШИНЭЭР ИЛРҮҮЛЭН ОЛСОН ХҮН ЧУЛУУДЫН ТУХАЙ

Н.БАЯРХҮҮ<sup>1</sup>, Т.ИДЭРХАНГАЙ<sup>2</sup>

<sup>1</sup>ШУА-ийн Археологийн хүрээлэн  
e-mail: n\_bayarkhuu04@yahoo.com

<sup>2</sup>МУБИС-ийн Монголын түүхийн тэнхим  
e-mail: iderkhangai@yahoo.com

*Түлхүүр үг. Түрэгийн үе, Мухдагийн ам, Хоньчины шил, хүн чулуу.*

**Өгүүллийн товч агуулга:** Тус өгүүлэлд Орхон голын хөндийгөөс шинээр олж илрүүлсэн хоёр хүн чулуун хөшөөний эрдэм шинжилгээний тодорхойлолт, гар зураг, гэрэл зураг, дурсгалын солбилцлын цэг зэргийг хамтатган анх удаа нийтлүүлж, судалгааны эргэлтэнд оруулж байгаа болно. Хүн чулуун хөшөөдийг манай орны Алтай, Хангай, Хэнтийн нуруугаар тархсан нийт хүн чулуудтай харьцуулан үзэж он цагийн хувьд түрэгийн үед холбогдоно хэмээн үзэж байна. Түүнчлэн өнөөг хүртэл Өвөрхангай аймгийн нутгаас болон Орхоны хөндийгөөс олж илрүүлээд байсан мөн үед холбогдох хүн чулуун хөшөөдийн тоог хоёроор нэмж судалгааны хэрэглэгдэхүүнийг баяжуулж буй юм.

Орхон голын сав газарт нүүдэлчид эртнээс оршин сууж, өөрсдийн төр улсын төвөө удаа дараа байгуулсаар ирсэн эртний түүхт өлгий нутаг юм. Тус нутгаас илрүүлэн олсон түүх, археологийн дурсгалууд нь чулуун зэвсгийн үеийн бууц суурин, дархны газраас дундад зууны үеийн булш оршуулга, барилга байгууламж, сүм хийд, хот зэрэг түүхийн олон үеийг хамарсан, олон төрлийн зуу зуун дурсгал бидний үед уламжлагдан хадгалагдаж иржээ.

Эдгээр хосгүй гайхамшигт дурсгалуудыг Дэлхийн соёлын өвд бүртгүүлэх, хадгалах хамгаалах талаар сүүлийн жилүүдэд нэлээд ажил хийгдэж байгаа билээ. Энэ ажлын хүрээнд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын газраас Орхон голын хөндийд археологийн хайгуулын ажил хийж гүйцэтгэхээр болж судалгааны баг бүрдүүлэн Орхон голын хөндийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Хотонт, Өгийнуур, Хашаат зэрэг сумдын зарим нутгаар хязгаарлаж, нарийвчилсан хайгуул хийж олон арван дурсгалыг шинээр бүртгэн тэмдэглэлээ. Хайгуулын ажлын хэсэгт: ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын ажилтан А.Дүүрэнжаргал, ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн Дундад зууны үеийн археологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Н.Баярхүү, МУБИС-ийн магистрант Т.Идэрхангай, Хархорин Дээд Сургуулийн багш Х.Адъяасүрэн нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг 2007 оны 9-р сарын 23-наас 10-р сарын 4-ний хооронд ажилласан билээ.

Судалгааны аргазүйн хувьд дээр дурдсан маршрутын дагуу автомашинаар явж шаардлагатай үед хайгуулаа явган алхаж хийлээ. Ингэхдээ нүдэнд харагдах эртний байж болох бүх төрлийн дурсгалуудыг үзэж, гэрэл зураг, байршил зэргийг тогтоон, эрдэм шинжилгээний тодорхойлолтыг газар дээр нь үйлдэн баримтжуулж явсан юм.



Олон жилийн судалгааны үр дүнд дурсгалуудын гэрэл зураг, ерөнхий дэвсгэр зураг, гар зураг, бичээсүүдийн хэв хуулга зэргийг нэгтгэн “Монголын эртний дурсгалын атлас” хэмээх 4 боть (Радлов, 1892; 1893; 1896; 1899), судалгааны ажлын тайлангуудыг нэгтгэсэн “Орхоны шинжилгээний ангийн бүтээлийн эмхэтгэл” хэмээх 5 боть хэвлэгдэн гарсан (Сборник трудов Орхонской экспедиции, 1892; 1895; 1897; 1897; 1901) бөгөөд уг бүтээл нь монгол орны төв хэсгийн эртний дурсгалуудыг цогц байдлаар судалсан эрдэм шинжилгээний асар их ач холбогдол бүхий бүтээл болсон тул өнөөг хүртэл үнэ цэнтэй хэвээр байгаа юм.


Үүнээс гадна Орхон голын хөндийгөөр Монгол зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн дурсгал судлах ангийнхан 1985-1986 онуудад судалгаа шинжилгээ хийж палеолитийн үеийн дархны газрууд олныг нээж илрүүлсэн бөгөөд эдгээрээс хамгийн алдартай нь болох эрдэм шинжилгээний ном зохиолд “Орхон-7” хэмээн нэрлэгдэж ирсэн чулуун зэвсгийн үеийн бууц, дархны газрыг нээж илрүүлж байжээ (Монгол..., 2006).

Дээрх судалгаануудаас гадна археологич доктор, профессор Д.Баяр Өвөрхангай аймгийн нутаг дахь түрэгийн үеийн хүн чулуун хөшөөдийн талаар эрдэм шинжилгээний тусгай өгүүлэл бичиж хэвлүүлсэн бөгөөд уг өгүүлэлд тухайн үед илэрч олдоод байсан хүн чулуудын холбогдох он цаг, дүрсэлвэр, гар зураг зэргийг эмхэтгэн нийтэлсэн нь тус аймгийн хүн чулуудыг нэгтгэн нийтэлсэн анхны судалгаа болсон байна (Баяр, 1992: 29-52). Тухайн үед Орхон голын хөндийгөөс (зөвхөн Өвөрхангай аймгийн нутагт багтах хэсгээс) ердөө ганц хүн чулуу илэрч олдоод байсан нь Хужирт сумын нутаг, Бэрхийн булангийн тахилын хашлага бүхий хүн чулуу юм.


Мөн 1997 онд археологич Д.Баяр төв Монголын түрэгийн үеийн нийт хүн чулуун хөшөөдийг нэгтгэн эмхэлж ерөнхий ангилал, холбогдох он цаг, дүрсэлгдсэн хувцас хунар, гоёл чимэглэл, зэр зэвсгийн зүйлс зэргийг нарийвчлан судалж нэгэн сэдэвт бүтээл нийтлүүлсэн (Баяр, 1997) нь энэ төрлийн дурсгалын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээл болсон төдийгүй эрдэмтэн судлаачид, оюутан залууст чухал гарын авлага, эх хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ.

Энэхүү өгүүлэлд дээр дурдсан хайгуулын судалгааны явцад Орхон голын хөндийгөөс шинээр илрүүлэн олсон түрэгийн үеийн хоёр хүн чулуун хөшөөний талаарх анхны мэдээлэл болон эрдэм шинжилгээний тодорхойлолт, гар зураг, гэрэл зураг, байршлын цэг зэргийг хамтатган нийтэлхийн сацуу холбогдох он цагийн талаарх өөрсдийн санлыг тусгасан бөгөөд эрдэмтэн судлаачид цаашид нарийвчлан судлах биз ээ.


**1-р хүн чулуу.** Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг, сумын төвөөс баруун урагш 10 гаруй км-т Орхон голын зүүн эрэг, Мухдагийн ам хэмээх нэгэн жижиг аманд бий. Энэ нь ДТД 1492 м, умард өргөргийн 47°07'2.61", дорнод уртрагийн 102°46'6.72" солбилцолд оршино. Энэ орчимд булш, хиргисүүр болон түрэгийн үеийн тахилын онгон нэлээд олон бий. Уг тахилын онгодын хамгийн зүүн урд захын сондгой ганц тахилын онгоны зүүнтэй баруун хажуугаараа газар унан булагдсан нэгэн хүн чулуун хөшөө байсныг бид илрүүлэн олсон юм. Уг хүн чулууны анхны байрлал алдагдсан бөгөөд тахилын хашлаганы гадаад хэлбэрч мөн эвдэгдсэн байдалтай байв. Хүн чулуу тахилын хашлаганы зүүн талд зүүн эгэмнээс баруун мөр хүртэл ташуу цуурч хугаран хоёр хэсэг болон унаж газарт булагдсан байлаа. Газарт булагдсан энэ хүн чулуун хөшөөний ил харагдаж байсан хэсэг нь ердөө л зүүн гарын тохой орчмын хэсэг, толгойны оройн хэсэг бөгөөд дүрслэлийн хувьд элэгдэж бүдгэрсэн тул энгийн хүний нүдээр харахад бараг мэдэгдэхгүй шахам болсон байв (Зураг 1).



Зураг 1. Мухдагийн амны хүн чулуун хөшөө



Зураг 2. Мухдагийн амны хүн чулуу



Зураг 3. Хоньчины шилийн хүн чулуу



Зураг 4. Хоньчины шилийн хүн чулуун хөшөө

Хүн чулууг цайвар шаргал боржин чулуугаар үйлдсэн бөгөөд он цагийн урт, байгаль цаг уурын нөлөөгөөр дүрслэл ихэд элэгдэж бүдгэрсэн байна. Хугарч унасан толгойн хэсэгт урт хамар гарган хамрын угаас хоёр тийш үргэлжлүүлэн хөмсгийг гаргаж түүний дор нүдийг, мөн жижиг живэр сахал, ам, чих, чихнээс доош жижиг дугуй хэлбэрийн ээмэг зэргийг дүрсэлжээ (Зураг 2). Харин их биеийн хэсэгт баруун гарыг тохойгоороо нугалан гартаа аяга мэт зүйлийг цээжин тус барьж, зүүн гараа тохойгоор хагас нугалан бүснээс барьсан бололтой байна. Бүс нь урд талаараа элэгдэж тодорхой мэдэгдэхгүй болсон бөгөөд харин зүүн баруун тохойны доогуур дөрвөлжин хэлбэрийн товруутай болох нь маш тод харагдаж байна. Мөн бүснээс баруун ташааруу унжуулан зүүсэн хавтагыг илэрхий товойлгон дүрсэлсэн ажээ.

**2-р хүн чулуу.** Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг, сумын төвөөс баруун урагш 20 гаруй км-т Хоньчны шил хэмээх газарт, багахан толгойн өвөр хонхорт том ширхэгтэй цайвар саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн нэгэн хүн чулуун хөшөө бий. Хүн чулуун хөшөө ДТД 1570 м-ийн өндөрт орших ба умард өргөргийн  $47^{\circ}3'21.99''$ , дорнод уртрагийн  $102^{\circ}41'4.45''$  солбилцолд оршино. Хүн чулуун хөшөө нь 0.63 м-ийн урт, 0.48 м өргөн, 0.2 м-ийн зузаантай. Дүрслэлийн хувьд нар салхи зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр ихэд элэгдэж мөлийсөн бөгөөд хөшөөний анхны байрлал алдагдаж одоо хуучин тахилын хашлаганыхаа төв хэсгийн хонхорт зүүн хойд зүг хандсан босоо байдалтайгаар байх ба толгой нь хүзүүний хэсгээр хугарч унан дэргэд нь сул хэвтэж байна. Уг хугарсан толгой нь хамарны дунд хэсгээс дээш дахин хугарч одоо тэр хэсэг нь алга болжээ (Зураг 3). Харин их биеийн хэсэгт баруун гарыг тохойн үеэр нугалан цээжин тус нарийн амсартай цүлхэн хэлбэрийн савыг эрхий болон долоовор хуруугаар барьсан, зүүн гарыг хагас нугалан бүснээс зүүсэн сэлэмний бариул дээр тавьсан байдалтайгаар дүрсэлсний эрхий хуруунаас бусад дөрвөн хуруу нь тод мэдэгдэж байна. Баруун болон зүүн тохойны доогуур оруулан дүрсэлсэн дөрвөлжин товруу бүхий бүснээс баруун ташаанд хавтга, зүүн ташаанд сэлэмний үзүүрийг махийлгасан байдалтайгаар товойлгон дүрсэлжээ (Зураг 4).

Хүн чулуун хөшөөдийн үйлдсэн ур хийц, дүрсэлсэн эд өлгийн зүйлс, тахилын онгоны дэргэд байгаа байдал зэргийг бусад дурсгалууд, ялангуяа манай орны төв болон баруун бүсийн нутгаар түгээмэл тархсан ур хийцтэй хүн чулуудтай харьцуулан үзэхэд онцын ялгаагүй байгаа тул эдгээр нь Түрэгийн үе буюу VI-VIII зууны үед холбогдох дурсгал хэмээн үзэж байна.

Ийнхүү Өвөрхангай аймгийн нутгаас илрүүлэн олоод байсан хүн чулуун хөшөөд, тэр дундаа Орхон голын хөндий дэхь хүн чулуун хөшөөний тоог хоёроор нэмэн судалгааны эргэлтэнд оруулж байгаа бөгөөд энэ тоо цаашид улам бүр нэмэгдэх нь гарцаагүй юм.

## НОМЗҮЙ

- Баяр Д., 1992. Өвөрхангай аймгийн нутагт буй түрэгийн үеийн хүн хөшөөний тухай. Археологийн судлал, Т.13, Fasc. 4, 29-52.
- Баяр Д., 1997. Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу. УБ.
- Баяр Д., Эрдэнэбаатар Д., 1999. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. УБ.
- Баярхүү Н., Идэрхангай Т., 2007. Орхоны хөндийд археологийн хайгуулын судалгаа хийсэн ажлын хэсгийн тайлан. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын газар, гар бичмэлийн сан. УБ.
- Клеменц Д.А., 1892. Письмо Д.А.Клеменца на имя академика Радлова. СТОЭ. Вып. I, Спб.
- Клеменц Д.А., 1895. Археологический дневник поездки в Среднюю Монголию в 1891 году. СТОЭ. Вып. II, Спб.
- Клеменц Д.А., 1895. Краткий отчет о путешествии по Монголии за 1894. ИИ АН. Спб.
- Монгол нутаг дахь түүх соёлын дурсгалуудын хадгалалт хамгаалалт, 2006. УБ.
- Потанин Г.Н., 1881. Очерки северо-западной Монголии. Спб. Вып.У1. с. 50-75.
- Радлов В.В., 1892. Атлас древностей Монголии. СПб. Вып. I.
- Радлов В.В., 1893. Атлас древностей Монголии. СПб. Вып. II.
- Радлов В.В., 1896. Атлас древностей Монголии. СПб. Вып. III.
- Радлов В.В., 1899. Атлас древностей Монголии. СПб. Вып. IV.
- Сборник трудов Орхонской экспедиции, 1892. Спб., Вып. I.
- Сборник трудов Орхонской экспедиции, 1895. Спб., Вып. II.
- Сборник трудов Орхонской экспедиции, 1897. Спб., Вып. III.
- Сборник трудов Орхонской экспедиции, 1897. Спб., Вып. IV.
- Сборник трудов Орхонской экспедиции, 1901. Спб., Вып. V.
- Ядринцев Н.М., 1892. О каменных бабах Сибири и Монголии. Труды VIII археологического съезда в Москве, 1890. т. IV, М.
- Ядринцев Н.М., 1892. Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889, СТОЭ. СПб., Вып. I.
- Ядринцев Н.М., 1892. Предварительный отчет об исследованиях по реке Толе, Орхону и в Южном Хангае. СТОЭ., СПб., Вып. I.
- Ядринцев Н.М., 1901. Отчет и дневник путешествий по Орхону и Южный Хангай в 1891 году. СТОЭ., СПб., Вып. V.

## SUMMARY

N.Bayarkhuu, T.Iderkhangay

### NEWLY DISCOVERED STONE STATUES FROM ORKHON VALLEY

Several nomadic empires established their political centers in Orkhon valley, due to his favorable geographical location. Thousands of archaeological sites were known in this remote area, but still been discovered new monuments by archaeologists.

An archaeological team conducted extensive survey in this region in October 2007, and discovered hundreds of new sites. Among them two stone statue of early Turkic period been discovered. In this article the authors presented the study of these statues dated by 6-8<sup>th</sup> century AD.